

Хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттөмөр Энхцэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Боловсролын хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах							
1	Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагыг боловсруулж, батлуулна. (ГБХНХЯ-тай хамтрах)	Баримт бичиг	-	-	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг ЕБГ-ын мэргэжилтэнтэй хамтран боловсруулахад санал өгч, хэлэлцүүлэгт оролцон, ажиллав. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл (2025.04.11), нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлэхэд оролцсон. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг ЕБГ-ын мэргэжилтэнтэй хамтран боловсруулахад санал өгч, хэлэлцүүлэгт оролцон, ажиллав. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл	4-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					(2025.04.11), нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлэхэд оролцсон. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.9-д уг нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан тул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025.05.09-ний өдрийн 1/1974 тоот), хамтран батлахаар албан бичиг хүргүүлсэн. Тус байгууллагуудаас батлагдан ирүүлэхийг хүлээж байна. Хавсралт: 2 файл		
2	"Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжлийг үнэлэх журам"-ын төсөл боловсруулж, батлуулна.	Баримт бичиг	БСШУС-ын сайдын 2020 оны А/280 дугаар тушаал	-	Журмын төслийг боловсруулах үе шатанд санал авах хүрээнд 8 хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулсан. Үүнд: 1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хүрээнд туршилтын 18 цэцэрлэгийн багш нар хүүхдийн хөгжлийн явцын үнэлгээг хийж буй байдал, үр дүн, өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээг хэрхэн хийж буй туршлага, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, СӨБХ-ийн дарга, мэргэжилтнээс өгсөн саналын дагуу сайжруулалт хийсэн. 2025.04.15-ны өдөр БЯ-ы СӨБХ-ийн удирдлага, мэргэжилтнүүд, БСҮХ, БЕГ, БҮТ-ийн мэргэжилтнүүдийн уулзалт, хэлэлцүүлэг; 2. 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Боловсролын яамны СӨБХ-ийн дарга, шинжээч, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, БЕГ-ын мэргэжилтнүүдээс бүрдсэн 13 оролцогчдыг хамруулсан хэлэлцүүлэг; 3. 2025 оны 5 дугаар сарын 07-ны өдөр БЯ-ы СӨБХ-ийн дарга, шинжээч, мэргэжилтнүүдийн уулзалт, хэлэлцүүлэг; 4. 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр БЯ-ы СӨБХ-ийн дарга, шинжээч, мэргэжилтэн, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд, БҮТ, БЕГ-ын мэргэжилтнүүд, нийт 15 оролцогч оролцсон "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын баг"-ийн зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг; 5. 2025 оны 5 дугаар сарын 14-ний өдөр СӨБ-ын сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулсан багийн нийт 25 оролцогч цахим, танхимын уулзалт, хэлэлцүүлэг; 6. 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр СӨБ-	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчийн төлөөлөл нийт 22 оролцогч оролцсон уулзалт, хэлэлцүүлэг; 7. 2025 оны 5 дугаар сарын 22-ны өдөр НБГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн 3.Болормаатай хийсэн уулзалт, хэлэлцүүлэг; 8. 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр БЯ-ны СӨБХ-т хэлэлцүүлэн өгсөн саналыг төсөлд тусгасан болно. Журмын төслийг боловсруулан 365 программд оруулан хянуулахад бэлэн болсон. Хавсралт: 8 файл		
3	Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг батлуулан, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллана.	Баримт бичиг	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг туршиж байна.	-	Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн "Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн зохиох, хянах багийн бүрэлдэхүүн батлах тухай" А/06 дугаар тушаалын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулах багийн гишүүнээр ажиллаж байна. Дараах байдлаар багаараа сайжруулалтыг хийж, хэрэгжилтэд бэлтгэн ханган ажиллаж байна. 1. 2025 оны 04 дүгээр сарын 01-06-ны өдрүүдэд "Энхийн төлөө" газарт багаараа вакумжиж, туршилтын сургалтын хөтөлбөрийн эрүүл мэндийн сургалтын чиглэлийн суралцахуйн үр дүн рүү чиглэсэн шалгуурыг багаараа хамтран боловсруулж, сайжруулсан. 2. "СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн туршилт 2024" ахлах бүлгийн багш нарын цахим ангийн хэлэлцүүлгийг удирдан, мэдээлэл оруулан ажиллаж байна. 3. "Чанга уншлагын арга зүйг нэвтрүүлэх нь" СӨБ-ын багш, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан цуврал видео хичээлийн бэлтгэл ажлыг хангаж ажилласан ба бичлэгийн эхний 4 модуль хэсэг Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар цацагдаж эхэлсэн. 4. Сургуулийн өмнөх боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн үнэлгээний шалгуур, суралцахуйн үр дүнд хөтөлбөрийн багийн гишүүдтэй хамтран матриц дүн шинжилгээ хийж ажиллаж байна. 5. "Шинжлэн судлахад суурилсан арга зүй", "Сонирхон судлахад суурилсан арга зүй" цуврал видео хичээлийн төслийг багаараа хамтран хэлэлцэж, зураглалыг гаргасан. Шаардлагатай бичлэгийг нийслэлийн туршилтын цэцэрлэгүүд дээр очиж авч	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					бэлтгэл ажлыг хангаад байна. Хавсралт: 7 файл		
4	Сургуулийн өмнөх боловсролын н хувилбарт сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийж, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг сайжруулах санал боловсруулах	Хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо	11,660	11,660	1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны “Журам батлах тухай” А/224 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгт хувилбарт сургалт зохион байгуулах журам"-д зааснаар "Нүүдлийн бүлгийн сургалт"-ыг зуны улиралд зохион байгуулдаг. Иймээс 2025 он 06-08 дугаар сард хувилбарт сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын үйлчилгээ тэр дундаа тавилга тоног төхөөрөмж, гэр болон зөөврийн сууцны аюулгүй байдал, багш, хүүхдийн ном гарын авлага, сургалтын чанар, үр дүнг сайжруулах санал боловсруулах ажил хийгдэнэ. 2. 2025 оны 5 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд "БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИИДЭЛ АРГА ЗАМ-2025" эрдэм шинжилгээний хуралд хамтарсан илтгэлээ хэлэлцүүлэв. Илтгэлд хувилбарт сургалтын багш нарын явцын үнэлгээ хийж буй байдалд хийсэн судалгааны үр дүнг танилцуулсан. Илтгэлийг Боловсролын ерөнхий газрын пэйж хуудсаар шууд дамжуулсан тул холбоосыг хавсаргав. https://www.facebook.com/share/v/1AW9PdJwa8/?mibextid=wwXlfr Хавсралт: 3 файл	5-р сар, 6-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 0%
1.2. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги", "Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
5	Цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх, "Гэрт ойр цэцэрлэг-хамгийн	Бүлэг дүүргэлт өндөртэй бүлгийн эзлэх хувь	72.2	-	"Гэрт ойр цэцэрлэг" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үе шаттай ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Аймаг, нийслэлийн нийт цэцэрлэгийн хамран сургалт, бүлэг дүүргэлтийн судалгааг 2025 оны 4-5 дугаар сард хийсэн. Энэхүү судалгаанаас үзэхэд нийслэлийн цэцэрлэгийн нийт бүлгийн 28,9 хувь 36-45 хүүхэдтэй, 9,5 хувь нь 46-аас дээш хүүхэдтэй, 5 аймгийн төвийн зарим цэцэрлэгийн бүлэг дүүргэлт 30-38 хүүхэдтэй байна. Мөн Боловсролын салбарын 2024-2025 оны статистик	5-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ: 70%

	сайн цэцэрлэг" арга хэмжээний төлөвлөгөө боловсруул ж, хэрэгжүүлэх				мэдээллээс үзэхэд 2-5 нас болон 5 настны хамран сургалтыг нэмэгдүүлэх, нийслэлийн огт цэцэрлэггүй 12 хороонд цэцэрлэг барих, салбар бүлгийн зохицуулалт хийх чиглэлээр 12 аймаг, нийслэлийн 6 дүүргийн Засаг даргад албан бичиг төлөвлөн хэлтсийн даргаар хянуулж байна. Тус албан бичигт: - Бүлэг дүүргэлтийг цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмд заасан тоонд барихад чиглэсэн арга хэмжээ авах - Орон нутгийн хэрэгцээнд нийцсэн шинэ цэцэрлэг барих төлөвлөгөө гаргах. - Одоогийн барилга байгууламжийг өргөтгөх, багтаамжийг нэмэгдүүлэх. - Салбар бүлэг нээх зэргээр хэд хэдэн чиглэл хүргүүлэхээр ажиллаж байна Хавсралт: 1 файл		Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Нялх балчир насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ .	Хамрагдсан хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчи йн тоо	-	-	2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр НҮБ-ын Хүүхдийн сан болон “Монос косметик” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт хийж, бага насны хүүхдийг зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр багш, эцэг эх , асран хамгаалагчдад хүргэх сургалтын болон нөлөөллийн ажлыг хамтран зохион байгуулахаар тохиролцон, эцэг эх, асран хамгаалагчдад хүргэх зарим нөлөөллийн ажлыг эхлүүлээд байна. Зуны улиралд бага насны хүүхдийн осол гэмтэл нэмэгддэг тул энэ ажлыг 7-8 дугаар сард болон 2025-2026 оны хичээлийн жилд үргэлжлүүлэх зохион байгуулахаар талууд тохиролцсон ач холбогдолтой арга хэмжээ болох юм. Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 10-р сар, 12- р сар	Өөрийн үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 0%
3.1. Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.							
7	Сургуулийн өмнөх боловсролы н салбарын мэдээллийн	-	2024 оны хэрэгжилти йн суурь түвшин	Холбогдо х заалтын хэрэгжил т	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35.2 дахь зүйл төрийн цахим үйл ажиллагааны талаар үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр "Кибер гэмт хэрэг ба хууль эрх зүйн орчин"	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	ил тод байдлыг ханган ажиллах			хангагдсан байна.	сургалтад хамрагдсан.	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3.2. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах							
8	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагналт.	2024 оны хэрэгжилтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	1. Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргад Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/280 дугаар тушаал “Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ын хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээг танилцуулж, тайлагнасан. 2. УИХ-ын 2020 оны “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52-р тогтоолын 2-р хавсралын 2.1.16 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 14.2 дахь заалт, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө /2021-2030/, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны “Хүүхдийн цэцэрлэгт ээлжийн багш ажиллуулахад мөрдөх журам” зэрэг баримт бичигт цэцэрлэгийн багшийн ажлын ачааллыг бууруулж, сургалт, үйл ажиллагаанд бэлтгэх, хүүхдийг ажиглах, судалгаа хийх, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор ээлжийн багшийг ажиллуулахаар тусгасан. Ээлжийн багш ажиллуулж байгаатай холбогдуулан бэлтгэсэн /Б.Мөнхзаяа ахлах шинжээч/ мэдээлэлд нэмэлт	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					зүйлсийг тусган СӨБХ-ийн Ж.Мягмар даргад илгээсэн. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монгол бичгийн дунд шатны мэдлэг чадварыг эзэмших	1. Монгол бичгийг бие даан судлах 2. Монгол бичгийн цахим сургалтад хамрагдах	Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрагдсан.	Монгол бичгийн цахим сургалтад хамрагдсан байна.	Боловсролын яамны албан хаагчдын дунд явуулж буй монгол бичгийн сургалтад 7 хоногт нэг удаа, нийт 3 удаа танхимаар хамрагдсан. Хавсралт: 1 файл	6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Англи хэлний сонсох чадвараа бие даан сайжруулах	- Тодорхой сэдвийн хүрээнд англи хэлээр аудиог сонсож, цээжлэх - Онлайн сургалтад хамрагдах	My cat speaks english буюу супер баруун тархины англи хэл” номоос 5 сэдвийн хүрээнд аудиог сонсож цээжилсэн.	Онлайн сургалтад хамрагдсан байна.	“Seattle ESL School”-ийн насанд хүрэгчдэд зориулсан “Adult Speaking Class 1” ярианы ангид онлайнаар хичээллэж, бие даан суралцаж байна. Хичээл нь долоо хоног бүрийн бямба, ням гарагуудад 45 минутын хугацаатайгаар явагддаг. Хавсралт: 2 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн цогц хөгжлийн бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттөмөр

Энхцэцэг /...../

Огноо: